

Жим ба түүний захиалгууд

Жим-ийн бургерын газарт үйлчлүүлэгчид дараалан зогссон байна. Захиалгаас хамаарч бэлтгэх хугацаа нь янз янз байдаг.

Ямар дарааллаар үйлчлүүлэгчид захиалсан хоолоо хүлээн авахыг тодорхойл.

Эхлээд дараалалд байгаа үйлчлүүлэгчдийг хамгийн урд байгаагаас нь хойд руу нь 1-ээс n хүртэл дугаарла.

Дараа нь танд үйлчлүүлэгч тус бүрийн захиалгын дугаар болон хоол бэлтгэх хугацаа өгөгдөнө.

Захиалга бэлэн болох хугацааг тооцолохдоо захиалгын дугаар болон хоол бэлтгэх хугацааг нэмнэ.

Хэрэв 2 захиалга зэрэг бэлэн болвол үйлчлүүлэгчийн дугаарын дарааллаар хоолыг хүргэнэ.

Жишээ нь :

Дараалалд 5 үйлчлүүлэгч байна. Үйлчлүүлэгч бүр захиалгын дугаар `order[i]` болон хоол бэлтгэх хугацаа `prep[i]`.

Үйлчлүүлэгч	1	2	3	4	5
Захиалгын дугаар	8	5	6	2	4
Хоол бэлтгэх хугацаа	3	6	2	3	3
Захиалга бэлэн болох хугацаа	11	11	8	5	7

Доорх дарааллаар үйлчлүүлэгчдэд захиалга хүргэгдэнэ.

Захиалга бэлэн болох хугацаагаар эрэмблэ	5	7	8	11	11
Үйлчлүүлэгч	4	5	3	1	2

Функцын тайлбар

`JimOrders` функцыг бич. Үйлчлүүлэгчдийн дугаарыг захиалгын гарах дарааллаар хэвлэнэ үү.

`JimOrders` доорх өгөгдлийг хүлээн авна

- Захиалгууд: 2 хэмжээст массив өгөгдөнө. (`order[i]`, `prep[i]`)

Оролтийн бүтэц

Эхний мөрөнд бүхэл тоо n, үйлчлүүлэгчдийн тоо

Дараагийн n мөрөнд 2 ширхэг зайгаар тусгаарлагдсан бүхэл тоонууд өгөгдөнө. Захиалгын дугаар ба хоол бэлтгэх хугацаа.

Хязгаарлалт

$$1 \leq n \leq 10^3$$

$$1 \leq i \leq n$$

$$1 \leq order[i], prep[i] \leq 10^6$$

Гаралтын бүтэц

Нэр мөрөнд үйлчлүүлэгчдийн дугаарыг (1-ээс n) захиалга бэлэн болох дарааллаар хэвлэнэ үү.

Хэрэв 2 ба түүнээс дээш үйлчлүүлэгч нэг зэрэг хоолоо хүлээн авах бол үйлчлүүлэгчдийн дугаарыг өсөх дарааллаар хэвлэнэ үү.

Жишээ оролт 0

3

1 3

2 3

3 3

Жишээ гаралт 0

1 2 3

Тайлбар 0

Жим-д дараах захиалгууд ирсэн:

1. $\text{Order}[1]=1$, $\text{prep}[1]=3$. Захиалга бэлэн болох хугацаа $t=1+3=4$
2. $\text{Order}[2]=2$, $\text{prep}[2]=3$. Захиалга бэлэн болох хугацаа $t=2+3=5$
3. $\text{Order}[3]=3$, $\text{prep}[3]=3$. Захиалга бэлэн болох хугацаа $t=3+3=6$

$\text{Order}[i]$ дахь i индекс нь үйлчлүүлэгчийн дугаар.

Жишээ Оролт 1

5

8 1

4 2

5 6

3 1

4 3

Жишээ Гаралт 1

4 2 5 1 3

Тайлбар 1

Жим-д дараах захиалгууд ирсэн:

1. $\text{Order}[1]=8$, $\text{prep}[1]=1$. Захиалга бэлэн болох хугацаа $t=8+1=9$
2. $\text{Order}[2]=4$, $\text{prep}[2]=2$. Захиалга бэлэн болох хугацаа $t=4+2=6$
3. $\text{Order}[3]=5$, $\text{prep}[3]=6$. Захиалга бэлэн болох хугацаа $t=5+6=11$
4. $\text{Order}[4]=3$, $\text{prep}[4]=1$. Захиалга бэлэн болох хугацаа $t=3+1=4$

5. $\text{Order}[5]=4$, $\text{prep}[5]=3$. Захиалга бэлэн болох хугацаа $t=4+3=7$

Захиалга бэлэн болох хугацаагаар эрэмбэлвэл дараах дараалал гарч ирнэ:

T=4: үйлчлүүлэгч 4

T=6: үйлчлүүлэгч 2

T=7: үйлчлүүлэгч 5

T=9: үйлчлүүлэгч 1

T=11: үйлчлүүлэгч 3

Тэмдэглэл

Жишээнд гарч ирээгүй ч гэсэн хэрэв захиалга нэг дор бэлэн болвол үйлчлүүлэгчдийн дугаараар эрэмбэлж хэвлэ.

Орчуулсан : Б.Мөнхбаяр АНУ